

ХАСБАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ ТАЙЛАН

Эми Чой

2023 оны 3 дугаар улирал



МЭДЭГДЭЛ

ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн Хараат бус гишүүн Эми Чой миний бие: (i) Компанийн тухай хууль (“КтХ”), Банкны тухай хууль (“БтХ”); (ii) Монголбанкны холбогдох журмууд болох “Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт шалгалтын журам” (“Засаглалын хяналт шалгалтын журам”), “Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам” (“Хараат бус гишүүний журам”); (iii) ХасБанкны Дүрэм болон бусад холбогдох засаглалын бодлого, зарчмын дагуу энэхүү Хараат бус гишүүний тайлан (“Тайлан”)-г бэлтгэсэн болно.

Тайлан нь дараах хугацааг хамарна: [2023 оны 3 дугаар улирал] (“Тайлант хугацаа”).

1. ОРОЛЦООНЫ ТАЙЛАГНАЛ

(Хараат бус гишүүний журмын 5 дугаар зүйлийн 5.2.1 болон 5.2.2 дахь заалт)

Тайлант хугацаанд Хүснэгт 1-д заасан дараах хурлуудад оролцож ажиллалаа.

Тайлант хугацаан дахь ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх Хороодын хурлууд

Хүснэгт 1

Хурлууд	Оролцсон байдал	Огноо
ТУЗ-ийн хурал	Хараат бус гишүүнээр	<ul style="list-style-type: none"> 2023 оны 7 дугаар сарын 07 2023 оны 9 дүгээр сарын 28
ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны хурал (“АХ”)	Хорооны гишүүнээр	<ul style="list-style-type: none"> 2023 оны 9 дүгээр сарын 28
ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны хурал (“ЭУХ”)	Хорооны гишүүнээр	<ul style="list-style-type: none"> 2023 оны 9 дүгээр сарын 28
ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшуулын хорооны хурал (“ЗНДЦУХ”)	Хорооны гишүүнээр	<ul style="list-style-type: none"> 2023 оны 8 дугаар сарын 18 2023 оны 9 дүгээр сарын 04 2023 оны 9 дүгээр сарын 28
Хувьцаа эзэмшигчдийн хурал	Хараат бус гишүүнээр	<ul style="list-style-type: none"> 2023 оны 9 дүгээр сарын 15

1.1 ТУЗ-ИЙН ХУРЛУУД

- ТУЗ-ийн ээлжит хурал 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр дараах асуудлуудыг хэлэлцэж, хуралдав. Үүнд:

- 1 ТУЗ-ийн өмнөх шийдвэр, зөвлөмжийн талаарх явцын мэдээлэл
- 2 ТУЗ-ийн дэргэдэх Хороодын тайлан:
 - 2.1 ЗНДЦУХ
 - 2.2 АХ
 - 2.3 ЭУХ
- 3 ХасБанкны нийтэд гаргасан хувьцааны талаарх явцын мэдээлэл
- 4 Мэдээллийн ил тод байдлын журам

- 5 ТУЗ-ийн гишүүд болон ажилтнуудын ёс зүйн кодекс ба сонирхлын зөрчлийн ерөнхий журам
- 6 Шүгэл үлээх бодлого (шинэ)
- 7 Авлига, хээл хахуулийн эсрэг ерөнхий журам (шинэ)
- 8 Дотоод мэдээлэл эзэмшигчийн арилжааны ерөнхий журам (шинэ)
- 9 Сонирхлын зөрчилтэй этгээд болон холбогдох этгээдтэй хэлцэл хийх журам (нэмэлт өөрчлөлт)
- 10 ТУЗ-ийн гишүүн болон Гүйцэтгэх удирдлагын даатгалын тухай явцын мэдээлэл
- 11 Нийтэд гаргасан хувьцааны орлого: ХасБанк ХК-ийн дүрэмд тусгах (зөвхөн хувь нийлүүлсэн хөрөнгө)
- 12 [Redacted]
- 13 Удирдлагын тайлан: (2023 оны 5 дугаар сар)
Эдийн засаг, банкны салбарын тайлан
Бизнесийн гүйцэтгэл
Санхүүгийн үр дүн ба цэвэр хүүгийн маржин
- 14 Мэдээллийн технологи & Цахим банкны талаарх явцын мэдээлэл
- 15 [Redacted]

Хэлэлцсэн асуудал #7, Авлига, хээл хахуулийн эсрэг ерөнхий журмын 3.3.1 дэх заалтад ТУЗ-ийн гишүүдийг (бүх ажилчдаас гадна) тус журмыг дагаж мөрдөх үүргийг нэмж оруулахыг санал болгов. Хорооны гишүүд миний саналыг зөвшөөрсөн.

Хэлэлцэх асуудал #12 батлах түвшинд хүрээгүй байгаа тул хэлэлцээгүй болно.

Хэлэлцсэн асуудал #13, Удирдлагын тайлангийн тухайд би зээлийн бүтэц нь иргэдийн банк (RB) [Redacted] байгууллагын банк (CB) [Redacted] болон Санхүүгийн түрээс /Лизинг/ [Redacted] байгааг ажиглаж, энэ нь бизнесийн 3 зээлийн бүтцийн зохистой харьцаа мөн эсэхийг асуув. Гүйцэтгэх захирал үүнд тийм гэж хариулж, иргэдийн банкинд анхаарлаа хандуулна гэдгийг илэрхийлэв. Би үүнд, иргэдийн банканд анхаарлаа хандуулах нь сайн боловч арилжааны банкны цогц үйл ажиллагааны тулгуур болох иргэдийн банк болон байгууллагын банк хоёрыг хамт авч үзэх нь чухал бөгөөд байгууллагын банкны эзлэх хувь [Redacted] доошгүй байх хэрэгтэй гэсэн саналыг хэлсэн. Мөн хүүгийн бус орлого (NII)-ын 5 дугаар сар хүртэлх өсөлтийн хувь (run rate) [Redacted] төгрөг байхад жилийн таамаглал нь [Redacted] төгрөг байгааг анзаарч, энэ зөрүүг арилгах үйл ажиллагааны төлөвлөгөөг асуусан. Гүйцэтгэх захирал нэмэлт хүүгийн бус орлогыг голчлон карт болон валют арилжаа бүрдүүлдэг гэж хариулсан.

[Redacted]

Мөн би ТУЗ-ийн хурлаас гадна 7-р сарын 06-ны өдрийн ТУЗ-ийн дэргэдэх ЗНДЦУХ, АХ болон ЭУХ тус бүрд ажиглагчаар оролцсон бөгөөд дараах саналыг хэлсэн:

Миний бие ТУЗ-ийн хурал болон Хороодуудын хурлын өмнө буюу 7-р сарын 05-ны өдөр банкны удирдлагуудтай хийсэн уулзалт болон 1 салбарт айлчилж дараах ажиглалт/саналтайгаар оролцов.

- Гүйцэтгэх захиралтай хийсэн уулзалт: Менежментийн сургалттай ижил төстэй сургалт болсныг Гүйцэтгэх захирлаас сонссоны дараа, ТУЗ-ийн гишүүдэд зориулсан хувьцаа нийтэд гаргасны дараах сургалт явуулах хүсэлтийг тавьсан. Энэхүү сургалт нь ТУЗ-ийн гишүүдэд тустай байх болно гэж үзсэн. Гүйцэтгэх захирал жилийн эцэс хүртэлх хугацаанд үүнийг зохион байгуулж болно гэж хариулсан.
 - Иргэдийн банк хариуцсан Захиралтай хийсэн уулзалт: МҮ-5-р сарын өсөлтийн хувь (run rate)-д үндэслэн хурдацтай хөгжиж байгаа “Эмэгтэйчүүдийн зээл” бүтээгдэхүүний хэмжээг өнгөрсөн жилээс хоёр дахин нэмэгдүүлэх боломжтойг ажигласан. Би хүлээгдэж буй олон тооны зээлийн гүйлгээг дэмжихийн тулд зээл эхлүүлэх/олгох/зарцуулах процессын автоматжуулалтын чадамжийн талаар асуусан. Иргэдийн банкны Захирал үүнд зээл олгох чанар дээр зах зээлд тэргүүлэгч байр сууриа хадгалахын тулд ихэнх процессуудыг автоматжуулсан гэж хариулав.
 - Мэдээллийн технологи хариуцсан Захиралтай хийсэн уулзалт: Би сүүлийн 2 жилийн хугацаанд мэдээлэл технологийн үндсэн банкны шинэчлэл ба мобайл банкны шилжилт хөдөлгөөнд амжилт гаргасанд баяр хүргэв. Бусад банкуудын мэдээллийн технологийн чадавхтай танилцсаны дараа би ирээдүйн автоматжуулалт, тухайлбал _____ нээх/харилцагчийн үйлчилгээ/харилцагчийн удирдлагын систем гэх мэт хиймэл оюун ухаан _____ санал болгов. _____ үйл явцын талаар хуваалцсан. Энэ нь зардал болон ажиллах хүчийг бууруулж, банкны үйлчилгээг авах газарзүйн хамрах хүрээг өргөжүүлж, илүү олон харилцагчтай болохын зэрэгцээ аюулгүй байдлын үүднээс хэрэгжүүлж болно.
 - Хотын салбар дахь айлчлал: Салбарын захирал, салбарын менежер, багийн ахлагч нараар бүрдсэн аз жаргалтай хамт олныг харж, төв оффисын дэмжлэгт сэтгэл хангалуун байлаа. Тэдний хамгийн том сорилт бол залуучууд гадаад улс руу явах болон Монгол дахь бусад банкууд руу шилжиж байгаатай холбоотой боловсон хүчний хомсдол юм. Энэ нь бусад банкуудад ч мөн сорилт болж байна. Ажиллагсад банкны хамгийн үнэ цэнтэй хөрөнгө учраас банкны ажилтнуудыг сонгон шалгаруулах, урамшуулах, сургах, үлдээх хөтөлбөрийг цаашид илүү хэрэгжүүлэхийг зөвлөсөн.
- **ТУЗ-ийн ээлжит хурал 2023 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр дараах асуудлуудыг хэлэлцэж, хуралдав. Үүнд:**
 - 1 ТУЗ-ийн өмнөх шийдвэр, зөвлөмжийн талаарх явцын мэдээлэл
 - 2 ТУЗ-ийн дэргэдэх Хороодын тайлан:
 - 2.1 ЗНДЦУХ
 - 2.2 АХ
 - 2.3 ЭУХ
 - 3 Удирдлагын тайлан: (2023 оны 8 дугаар сар)

Эдийн засаг, банкны салбарын тайлан

Бизнесийн гүйцэтгэл

Санхүүгийн үр дүн

4	
5	
6	
7	

Хэлэлцсэн асуудал #3: 7 дугаар сарын 07-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хуралд танилцуулснаас хойш хөрвөх чадварын харьцаа болон шимтгэлийн орлогын өсөлтийн хувь (run rate) нэг их сайжраагүй байгаад санаа зовж байгаагаа илэрхийлэв. Гүйцэтгэх захирал хэд хэдэн арга хэмжээ авч ажилласан талаар хэлсэн. Үүнд: иргэдийн хадгаламжийг нэмэгдүүлэх зорилгоор тусгай хувь санал болгох эрх мэдлийг тэргүүн эгнээнд олгосон мөн картын бизнесийн шимтгэлийн орлогыг нэмэгдүүлэхийн тулд илүү хүчин чармайлтыг гаргасан боловч үр дүн гарахад тодорхой хугацаа шаардагдах болно гэв. Миний зүгээс тогтвортой санхүүжилтийн стратеги хэрэгжүүлэхэд олон улсын санхүүжилт болон иргэдээс татан төвлөрүүлэх хадгаламж чухал ач холбогдолтой болохыг онцолж хэлсэн. Мөн 11 дүгээр сард болох ТУЗ-ийн хурлаар хадгаламж байршуулах ба шимтгэлийн орлого нэмэгдүүлэх төлөвлөгөө, үр дүнгийн талаар танилцуулахыг хүссэн.

Хэлэлцсэн асуудал #5, #6: ТУЗ-д төлөөлөлгүй жижиг хувьцаа эзэмшигчдэд шударга бус хандаж болзошгүй талаар санаа зовж буйгаа дахин илэрхийлсэн.

- Мөн түүнчлэн Хүснэгт 2-т заасан дараах ТУЗ-ийн цахим санал хураалтын хуралд оролцсон.

Тайлант хугацаан дахь ТУЗ-ийн цахим санал хураалтын хурлууд

Хүснэгт 2

Хурал	Санал хураалт	Огноо
ТУЗ-ийн цахим санал хураалтын хурал	ТУЗ-ийн 2023-2024 оны хурлын хуваарь батлах тухай	2023 оны 7 дугаар сарын 20-ны өдрөөс 8 дугаар сарын 04

Миний зүгээс санал болгож буй хурлын огноотой санал нийлсэн боловч, ТУЗ-ийн илүү үр дүнтэй харилцаа холбоог бий болгохын тулд биечилсэн 2, цахим 2 хурлын оронд ТУЗ-ийн 4 удаагийн биечилсэн ээлжит хурлыг илүүд үзсэн. Бусад ТУЗ-ийн гишүүд адилхан санал хэлсэн. Ингээд бүх гишүүд 2024 онд ТУЗ 4 удаа биечлэн хуралдах саналыг өгсөн.

1.2 ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ АУДИТЫН ХОРООНЫ ХУРАЛ (“АХ”)

Хүснэгт 3-т заасан дараах АХ-ны хурлуудад оролцсон.

Тайлант хугацаан дахь АХ-ны хурлууд

Хүснэгт 3

Огноо	Хэлэлцсэн асуудал
2023 оны 9 дүгээр сарын 28	<ol style="list-style-type: none"> 1. Аудитын хорооны даргыг сонгох тухай 2. Эрнст энд Янг Монголия Аудит ХХК-ийн хийсэн хагас жилийн тайлан 3. Аудитын тайлан <ol style="list-style-type: none"> 3.1 Орон нутгийн салбар 3.2 Мэдээллийн технологийн хөрөнгийн удирдлага 3.3 Үргэлжилсэн аудит

	3.4 Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тайлан 3.5 Тусгай активын газар 4. Банкны холбогдох этгээдүүдийн улирлын тайлан (МонголБанкны журам)
--	---

Хэлэлцсэн асуудал #1: Би Уламбаяр захирлыг АХ-ны даргаар үргэлжлүүлэн ажиллуулах саналыг дэвшүүлж, бүх гишүүд зөвшөөрөв.

Хэлэлцэх асуудлын #3: [REDACTED] гэх мэт аудитын ерөнхий асуудлуудыг бууруулахын тулд хамгаалалтын 2-р шугамыг бэхжүүлэх шаардлагатай байгаа талаар байр сууриа илэрхийлэв.

1.3 ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХОРООНЫ ХУРАЛ (“ЭУХ”)

Хүснэгт 4-т заасан дараах ЭУХ-ны хурлуудад оролцсон.

Тайлант хугацаан дахь ЭУХ-ны хурлууд

Хүснэгт4

Огноо	Хэлэлцсэн асуудал
2023 оны 9 дүгээр сарын 28	1. ЭУХ-ны хурлын даргыг сонгох тухай 2. 2023 оны 8 дугаар сарын байдлаарх эрсдэлийн тайлан 3. Авлига, хээл хахуулийн эсрэг ерөнхий журмын шинэчлэл 4. 2023 оны 8 дугаар сарын байдлаарх хянан нийцүүлэлтийн явцын мэдээлэл 5. 2023 оны 3 дугаар улирлын холбогдох этгээд /сонирхлын зөрчлийн хэлцлийг соёрхон батлах

Хэлэлцсэн асуудал #2: Эрсдэлийн тайлангийн хувьд, 2023 оны 8 дугаар сарын байдлаар [REDACTED], буюу хүний нөөцийн эргэлт өндөртэй байдлыг ажиглаж, 11 дүгээр сард болох ТУЗ-ийн хурлаар хүний нөөцийн хамгийн агшилттай газар, хэлтэст дэлгэрэнгүй дүн шинжилгээ хийж, ажилчдын стратеги төлөвлөгөөг танилцуулахыг хүссэн.

1.4 ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ЗАСАГЛАЛ, НЭР ДЭВШҮҮЛЭХ, ЦАЛИН УРАМШУУЛЫН ХОРООНЫ ХУРАЛ (“ЗНДЦУХ”)

Хүснэгт 5-т заасан дараах ЗНДЦУХ-ны хурлуудад оролцсон.

Тайлант хугацаан дахь ЗНДЦУХ-ны хурлууд

Хүснэгт5

Огноо	Хэлэлцсэн асуудал
2023 оны 8 дугаар сарын 18 (ээлжит бус)	1. ХасБанкны Хараат бус гишүүний 1 сул орон тооны сонгон шалгаруулалтын талаарх явцын мэдээлэл

Хараат бус гишүүний тайлан

2023 оны 9 дүгээр сарын 04 (ээлжит бус)	1. ХасБанкны Хараат бус гишүүний 1 сул орон тооны сонгон шалгаруулалтын талаарх явцын мэдээлэл
2023 оны 9 дүгээр сарын 28	1. ЗНДЦУХ-ны даргыг сонгох тухай 2. Монголбанкны зохистой засаглалын үнэлгээний тайлан 3. ХасБанкны Хараат бус гишүүний 1 сул орон тооны сонгон шалгаруулалтын талаарх явцын мэдээлэл 4. Хувьцааны үнэд суурилсан урамшууллын хөтөлбөр (PSP) болон Урт хугацааны урамшууллын төлөвлөгөө (LTIP)-д дүн шинжилгээ хийх ажлын хэсгийн явцын мэдээлэл 5. ЭУХ-ны гишүүнчлэл

Хэлэлцэх асуудал #4: Ажлын хэсгээс хувьцааны үнэд суурилсан урамшууллын хөтөлбөр (PSP) болон Урт хугацааны урамшууллын төлөвлөгөө (LTIP)-ийн дүн шинжилгээг танилцуулсан ба цалин урамшууллын нийт зардал үйл ажиллагааны нийт зардлын хэвээр байна. Энэ талаар надад өөр асуулт байгаагүй.

Хэлэлцэх асуудал #5 хэлэлцээгүй болно.

1.5 ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛ

Хүснэгт 6-д заасан 2023 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн **Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд** оролцов:

Хүснэгт 6

№	Хэлэлцсэн асуудал	Шийдвэрлэсэн байдал
1	Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох тухай тогтоолын төслийг батлах эсэх	Баталсан.
2	Банкны Дүрмийг батлах тухай тогтоолын төслийг батлах эсэх	Баталсан.

Тус хурал нь банк хувьцаагаа олон нийтэд анх удаа санал болгосны дараах анхдугаар түүхэн хувьцаа эзэмшигчдийн хурал байв. Хурлаар шийдвэрлэх хоёр асуудал саадгүй батлагдсан. Нэг хувьцаа эзэмшигч асуулт асууж, хурлын дэгт асуулт хариултын хэсэг байхгүй байсан хэдий ч удирдлагын зүгээс тэдгээр асуултуудад товчхон хариулсан.

Хурлын дараа, ТУЗ-ийн хараат бус гишүүд ТУЗ-ийн дарга, Засаглал, Нэр дэвүүлэх цалин урамшууллын хорооны дарга болон Гүйцэтгэх захирал нартай дараагийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зохион байгуулалтыг сайжруулах талаар уулзалт хийж, дараах саналууд гарсан:

1. Хувьцаа эзэмшигчдийн дуу хоолой, саналыг сонсох, мөн удирдлагын зүгээс тухайн цаг үед хариултыг нь өгөхийн тулд асуулт хариултын хэсгийг хурлын дэгт нэмж оруулах;
2. Хурлын өмнө болон дараа хувьцаа эзэмшигчдэд хангалттай анхаарал хандуулах, боломжит хөрөнгө оруулагчидтай идэвхтэй харилцах/роуд шоу хийх зорилгоор хөрөнгө оруулагчидтай харилцах үүргийг бий болгох; мөн

3. Өнгөрсөн хугацаанд хийсэн томоохон амжилтуудын талаарх нээлттэй видео бичлэг болон цаашдын гол стратегийг танилцуулсан хаалтын видео бичлэгийг нэмэх.

2. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ БА ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЛИЙН ТАЙЛАН

(БтХ-ийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг болон Хараат бус гишүүний журмын 5 дугаар зүйлийн 5.2.3 дахь заалт)

БтХ-ийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэгт Банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн нь сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлахад заавал оролцож, санал өгнө гэж заасан.

Тайлант хугацаанд, ТУЗ-ийн 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн хурлаар 12 сонирхлын зөрчилтэй хэлцэл, мөн ТУЗ-ийн 2023 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн хурлаар 3 сонирхлын зөрчилтэй хэлцэл, нийт 15 (арван тав) сонирхлын зөрчилтэй хэлцлийг баталсан. Эдгээр бүх хэлцэлд оролцож, саналаа өгч ажилласан.

ТУЗ-ийн гишүүдээс сонирхлын зөрчилтэй гишүүн байсан тохиолдолд тухайн гишүүн нь хурлын эхэнд ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ мэдэгдэж, хэлэлцсэн асуудалд санал өгөөгүй болохыг тэмдэглэж байна.

3. ЗАСАГЛАЛЫН ТАЙЛАН

(КтХ-ийн 79 дүгээр зүйлийн 79.3 дахь хэсэг, Хараат бус гишүүний журмын 5 дугаар зүйлийн 5.2.4 дахь заалт болон Засаглалын хяналт шалгалтын журмын 3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсэг)

Дээр дурдсан хууль тогтоомжоор Хараат бус гишүүн нь Банкны оролцогч талууд, түүний дотор Хувьцаа эзэмшигч, харилцагч, хадгаламж эзэмшигч болон банкны ажилтны эрх ашгийг хамгаалах үүднээс ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь Банкны эрх ашиг, сонирхолд нийцсэн эсэх, мөн үйл ажиллагаа нь хууль тогтоомж дүрэм журамд нийцсэн эсэхэд хяналт тавих эрхтэй.

Банкны засаглалыг дүгнэхэд:

КтХ-ийн 79 дүгээр зүйлийн 79.3 дахь хэсэгт заасан арга хэмжээ	
КтХ 79.3.1 болон Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.5 (БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУУЛЬ ТОГТООМЖ, ДҮРЭМ, ЖУРМЫН НИЙЦЭЛ)	ТУЗ болон удирдлагын баг хууль тогтоомжийг дагаж мөрдөхийн тулд бүх хүчин чармайлтаа гаргаж, нарийн зүйлүүдийг анхаарч авч үздэгийг ажигласан. Ялангуяа хатуу хуваарьтай байсан ч хувьцаагаа олон нийтэд санал болгох (IPO) үйл явцад бүх хүчин чармайлтаа гаргасан. Мөн IPO хийсний дараах эргэн хяналт, ТСН-ийг ХасБанктай нэгтгэх мөн 4 дэх хараат бус гишүүний сонгон шалгаруулалтын ажилд анхаарлаа хандуулан ажиллаж байна.
КтХ 79.3.2 (БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ)	Байхгүй/Зөрчил ажиглагдаагүй.

КтХ 79.3.3 (ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ)	2023 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд биечлэн оролцсон ба хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн асуултад хариулах, тодруулга хийхэд бэлэн байсан.
Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.1 (ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ГАРГАСАН ШИЙДВЭР НЬ БАНКНЫ ЭРХ АШИГТ НИЙЦСЭН ЭСЭХ)	ТУЗ болон удирдлагын багийн гаргасан шийдвэр нь банкны эрх ашигт нийцэж байгааг ажигласан.
Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.2 (ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦСЭН ЭСЭХ)	ТУЗ болон удирдлагын баг бүх цаг үед холбогдох хууль тогтоомжийн дагуу ажиллахыг хичээж ажиллаж байсныг ажигласан.
Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.3 (БАНКНЫ ХАРИЛЦАГЧ, ХАДГАЛАМЖ ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ)	Байхгүй/Зөрчил ажиглагдаагүй.
Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.6 (МОНГОЛБАНКИНД ЗӨРЧИЛ МЭДЭЭЛЭХ)	Байхгүй/Зөрчил ажиглагдаагүй.

4. БУСАД

Би 9 дүгээр сарын 27-ны өдөр стратегийн хурал/өдөрлөгт оролцож, ирэх 3 жилийн хугацаанд ХасБанкийг дижиталжуулах төлөвлөгөөг боловсруулах боломжийг бидэнд олгох үүднээс Хасбанк & Тэргүүлэгч банкууд болон ХасБанк & гадаад улсын шилдэг банкуудын хооронд дижиталчлалын зөрүүний шинжилгээний тайланг гаргахыг хүссэн.

Мөн 9 дүгээр сарын 14-ний өдөр Төв аймгийн хөдөө орон нутгийн салбар дээр зочилж, 18 дахь жилдээ тус банкинд ажиллаж байгаа үнэнч салбарын менежертэй уулзсандаа баяртай байсан. Тэрээр сүүлийн хэдэн жилийн хугацаанд ХасБанкны гүйцэтгэлийн гайхалтай өөрчлөлт, мөн төв албанаас үзүүлж буй маш сайн дэмжлэг, тууштай стратегиар бахархаж байгаа тухайгаа дурдсан. Түүний хамгийн том сорилт бол боловсон хүчний эргэлт, ялангуяа теллер, хувийн банкирын албан тушаалд буй “Z” үеийн ажилтнууд гэв. Түүнд “Z” үеийг сэтгэл ханамжтай байлгах сайхан санаанууд байсан. Тухайлбал стратегийн өдрийг зохион байгуулж, уян хатан байдал болон ажил мэргэжлийн сонирхлоо удирдлагын багтай хуваалцах байв.

Огноо: 2023 оны 10 дугаар сарын 08

Гарын үсэг: Эми Чой